

Огноо: 2025.12.02



Батлав.
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

Ж.ЭНХБАЯР




Ж.ЧИНБҮРЭН

П.НАРАНБАЯР

Х.ГАНХУЯГ

Батлав.
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Батлав.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД



МОНГОЛ УЛС БОЛОН АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН САНХҮҮЖИЛТИЙН
ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ

Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл, 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 103 дугаар захирамжийг тус тус үндэслэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт Сангийн сайд Б.Жавхлан 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр гарын үсэг зурсан.

Тус Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр “Аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл”, “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл - 2 дахь нэмэлт санхүүжилт”, “Монгол Улсын ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэх төсөл” болон “Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.